

Орон бүхний промтарын нар нэгдэгчүүн!

АНХ ДЭГДЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 35 (2299)

1974 оны 5 дугаар сарын 6

ДАВАА

ХӨДӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН СПАРТАКИАД

Хөдөөгийн хөдөлмөрчдийн дунд биеийн тамир, спортын хөдөлгөөнийг эрчимтэй өрнүүлэх, нэгдэл, САА, нэгдэл-дундын үйлдвэр, ТАА-н малчин, тариачин, ажилтан, ажилчдын эрүүл мэнд, бие бялдрын хүмүүжлийг улам сайжруулах, тэдний дундаас шилдэг тамирчдыг төрүүлэх зорилгоор БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж хөдөөгийн залуучуудын III спартакиадыг зохион явуулах болсон явдал юм. Энэхүү спартакиадаар биеийн тамирчин нийтийн арга хэмжээ болон эмнэг сургагчид, үндэсний бөх, сур, одон бөмбөг, хөнгөн атлетикийн тэмцээн зохиогдоно. Саяхан ХААУ газар, Нэгдлийн зөвлөл, ХЗЭ-ийн хороо, Ургац нийгэмлэгийн хамтарсан хурал болж бригад, ферм, тасгийн спартакиадыг 5 дугаар сарын 18, 19-нд нэгдэл, САА, нэгдэл дундын үйлдвэр, ТАА-н спартакиадыг 5 дугаар сарын 25, 26-нд, аймгийн нэгдсэн спартакиадыг 6 дугаар сарын 8, 9-нд Зуунмод хотын төвд зохион явуулахаар шийдвэрлэж спартакиадын зааврыг баталж гаргалаа.

Иймд ХАА-н нэгдэл, САА, нэгдэл дундын үйлдвэр, ТАА-н захиргаа, дэргэдэх эвлэлийн байгууллагуудтайгаа хамтарч спартакиадыг үзэл суртал, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахын тулд бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган салбар комисс байгуулж тэднийг нарийн төлөвлөгөөтэй ажиллуулах нь чухал.

Саяхан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс батлан гаргасан биеийн тамирын иж бүрэн хөтөлбөр ХБХБ тэмдгийн шинэ нормыг биелүүлэх ажил нь ард түмний оюуны болон зан суртахууны хүмүүжил, бүтээлч идэвхийг дээшлүүлэх, эрүүл чийрэг, урт удаан наслуулах, эх орноо батлан хамгаалахад боловч бүтээлч хөдөлмөрт бэлтгэх зорилттой юм.

Иймд ХАА-н байгууллагууд ХБХБ тэмдгийн нормын шинэ зааврын дагуу гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулалттай хийхийн хамт спортын секци дугуйлан байгуулж хичээллүүлэх, гимнастикийг тогтмолжуулах, тойрон аялал, нийтийн уралдаан зохиох, биеийн тамирын самбар, булан байгуулах, ахмад шилдэг тамирчидтай уулзалт хийх, үдэшлэг, гэгээрлийн хурал зохиох зэргээр спартакиадад бэлтгэх ажлыг ХАА-н үйлдвэрлэлийн цаг үеийн ажилтай нягт холбож явуулбал зохино.

Үүний тулд нэгдэл, САА-нууд спартакиадын арга хэмжээний нэг болох эмнэг хангал морь, тэмээг уналга идэвхэнд сургах ажлыг сайн зохион байгуулж, түүнд залуучуудыг олноор хамруулах, энэ талаар урьд өмнө тогтоосон дээд хэмжээг эвдэх, эмнэг хангалгүй аж ахуй, бригад, суурь болох хөдөлгөөнийг өрнүүлэх нь чухал байна.

Спартакиадад хөдөөгийн залуучуудыг бүрэн хамарч тэргүүний авъяаслаг тамирчдыг тодруулан гаргахад онцгой анхаарч аль болох бололцоо нөхцөлөөр хангах, ХАА-н байгууллага бүр биеийн тамир спортын талбай байгуулах, түүний материаллаг баазыг бэхжүүлэх, спортын хувцас, формыг санаачлан хийх тамирчдын амжилтыг дээшлүүлэх тодорхой зорилт дэвшүүлэн тавьж ажиллавал зохино. ХАА-н байгууллага түүний дэргэдэх эвлэлийн үүр, хороод биеийн тамирын анхан шатны байгууллагууд хамтарч залуучуудыг өргөн хамран оролцуулах зорилгоор спартакиадад оролцох спортын төрлүүдээс секци байгуулан хөдөөгийн залуучуудын 50 хувийг хамруулсан байх, ХБХБ тэмдгийн нормыг бүх хүмүүсийн 20-иос доошгүй хувь нь биелүүлдсэн байх, биеийн тамирын төрлүүдээр уулзалт уралдаан тэмцээнийг 10-аас доошгүй удаа зохиох, нийтийг хамарсан зугаалга, тойрон аялал, кросс, маршийн хүмүүсийн насны ялгавараар 3,5,10 км-ийн зайд 3 удаа зохиосон байх шаардлагатай. Спартакиадын урьдчилсан бэлтгэл залуучуудын хамрагдсан байдал, үзүүлсэн амжилтаар нь оноо өгч зохих байр эзлүүлэх юм.

Хамгийн гол нь бүх нийтийг хамарч тасаг, бригад, фермийн төвд хийх анхан шатны байгууллагын спартакиадыг зааврын дагуу чанартай хийснээр тэргүүний шилдэг тамирчдыг тодруулж чадна.

Таван жилийн төлөвлөгөөний тэргүүн эгнээнд хошуучлагчдад баяр хүргэе!



ЗУРАГ ДЭЭР: (Зүүн гараас) V таван жилийн төлөвлөгөөг 2 жилээс 2 жил 6 сарын өмнө биелүүлсэн гавшгайч НААУ-ийн газрын өсгүүрчин Ш. Дарьсүрэн, оёдолчин Хамдсүрэн, хивсчин Д.Долгоржав.

Л.ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРАЛ ХУРАЛДАХАД 23 ХОНОГ ҮЛДЛЭЭ

Аймгийн Намын хорооны товчоо, аймгийн намын XVI бага хурлыг энэ оны 5 дугаар сарын 30-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэн билээ.

Аймгийн намын бага хурал тус аймгийн намын байгууллагуудаас тайлангийн хугацаанд хийсэн ажлыг нэгтгэн дүгнэж, цаашдын зорилтыг тодорхойлох болно.

Аймгийнхаа намын дээд эрхийг барих тус бага хурлыг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтах нь манай аймгийн хөдөлмөрчдийн нэн тэргүүний зорилт болж байна.

Юуны урьд үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл, ар-

дын боловсрол, эрүүлийг хамгаалах болон бусад ахуй үйлчилгээний нийт газруудад бага хурлын нэрэмжит өндөр бүтээлийн 20 хоногийн ажлыг энэ 5 дугаар сарын 6-наас эхлэн явуулах ёстой.

Энэ хугацаанд үйлдвэрлэлийн төлөвлөгөө, социалист уралдааны үүргээ давуулан биелүүлэхэд бүхий л хүч бололцоогоо дайчлан ажиллавал зохино.

Өндөр бүтээлийн өдөрүүдийн нэг чухал зорилт нь төл бойжуулах, малын зүй бусын хорогдлыг багасгах ажлын явцыг улам сайжруулж бодын хөөвөр хялгас, ямааны ноолуу-

рыг богино хугацаанд шуурхай авч тариалалтыг чанартай хийж дуусгах явдал мөн.

Түүнчлэн бага хурлаа угтаж нөөц бололцоог илрүүлэн ашиглах шинэ санаачилга гаргаж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эрхэлсэн ажил дээрээ шинэ амжилт гаргах зэргээр хүн бүр тодорхой бүтээл гаргах идэвх хөдөлгөөнийг өрнүүлсэ.

И н г э ж ажилласнаар 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 23 хоногийн өмнө биелүүлэхээр дэвшүүлсэн зорилтыг 5 дугаар сард үндсэнд нь хангахын төлөө ажиллахаа.

ҮР СУУЛГАЖ БАЙНА

Архустын ТАА-н х а н атар газар эзэмшсэний 15 жилийн ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтаж, тэргүүний тариаланчдын улсын зөвлөгөөний шийдвэрийг биелүүлэхийн тулд социалист уралдаантай ажиллаж тариалалтын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна. Тухайлбал:

Талбайн 30 хувийг нь тоонолжлон тарих, эрдс бордоогоор 1370 га бордон, 1000 га-д авиан химийн аргаар хог ургамал устгах, актлагдсан СК—3 комбайн 2-ыг ашиглаж үр цэнэглэгч хийж ажилуулан, СЗП—3,6-г хатуу холбоо х и й ж ДТ—75

тракторт холбож үрэлгээнд хэрэглэв.

Мөн 4350 га-д борнойд, 4350-га-д булдалт, 4350-га-д сайтай хийж 7—10, хоногт багтаан дуусгаж, 1000 га-г эрдс бордоогоор бордох төлөвлөгөөг 370 га-гаар давуулж биелүүлэв.

Энэ ажилд 1 дүгээр бригадын тракторч Б.Цэрэндорж, Г.Батсүх, С.Пүрэв, II бригадын Жамсранжав, Загдгарав, Дашням нар тооцоотой үүрэг авч ажиллан нормоо 120—130 хувиар биелүүлж сайхан амжилт гаргалаа.

Үрлэлтийг ажлын 15 хоногт багтаан дуусгах зорилттой ажиллаж байна.

п.НАМСРАЙ

Кабинет байгуулав

Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар өөрийн шөф Бүрэн сумын Ж.Самбуугийн нэрэмжит «Бүрэн дэлгэрэх» нэгдэлд манай нам, төрийн нэрт зүтгэлтэн, олон улсын энх тайвны Лешиний шагналт агсан Ж.Самбуугийн үйл амьдралыг сурталчлах кабинет байгуулж өгснөө саяхан хүлээлгэн өгөв.

Энэ кабинет Ж.Самбуугийн үйл амьдрал, дайчин замналыг харуулсан фото зургууд, гадаад улсуудын болон өөрийн орны хөдөлмөрчдөөс дурсгасан бэлэг дурсгалын зүйлүүдээс бүрдсэн 150 шахам үзмэртэй юм. С.ЦЭДЭВ

Атрын 15 жилийн ойд

АТРЫНХАН АМЖИЛТТАЙ БАЙНА

Атрын 15 жилийн ойг ажил хөдөлмөрийн өрнүүлэн амжилтаар угтахаар манай аймгийн тариаланчид шамдаж байна.

Сонинхангай уулын зүүн сугад анхны шав тавьж атрын нэг САА-н тулгын чулууг тулалцсан, атраас алдир нэр нь тодорсон аварга сайчууд Угтаалын САА-д олон бий.

Тэдний заримтай уулзаж атрын 15 жилийн ойг угтаж хийж буй ажлаас нь асууж сонирхсон юм.

Атар буйд газрыг эзэмшиж тариалангийн үйлдвэрлэлийг арилгахаар манай нам эзэнт зорилтоо дөвшүүлж байсан 1961 онд олон авын хөвгүүд, охид Угтаалцайдамын тал руу мордлоо.

1961 оны хатуухан хаврын цас шоргоо буцгана-сан нэг өдөр Улаанбаатар хотоос гаран 70-аад залуу, 30-аа-и трактор, цөөхөн авто машин Сонинхангай уулын зүүнтэй шав тавьсан газар ирж буудалласнаас хойш би 13 жил трактор комбайн барьж төлөвлө өгсөө тогтмол давуулж ирлээ гэж Угтаалын САА-н 2 дугаар тасгийн тракторчин Ч.Пүрэвийг ярьж байхад мөн атрын анхны шав татац-цаж явсан тракторчин Жалсрай 13 жилд 17 жилийн ажил хийгээд энэ жил газар хагалах өдөр 6-р ийнхээ төлөвлөгөөг 150—180 хувь биелүүлэн атрын ойдоо бэлэг барьж байгаа тухайгаа сэтгэл хангалуун өгүүлж байв.

Галын уулын тасгийн 12 дугаар бригадын дарга Р.Гончигсүрэнтэй уулзал.

—Атрын анхны бригадын арван гурван техникчдээс намын гишүүн, тракторчин Баатар, эмэгтэй Бадамсүрэн, атрын анхны малчин байгаад хо-

жим тракторчин болсон Б.Сэмбэн нар одоо манай бригад ажиллаж байна.

Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг гэгчээр бид хамтын хүч чармайлтаа нэгтгэн ажиллаж сүүлийн 10 жил тогтвортой ургац авч улсын аварга бригад болсон амжилтаа бататган атрын 15 жилийн өг утгаж хаврын хагалаах үрлээг ажлын 15—17 хоногт дуусгах уралдаан өрнүүлэн өдөр бүрийнхээ төлөвлөгөөг давуулан биелүүлж байна гэв.

Атрын анхны жил ЗХУ-ын Сибир нутгийн дөрвөн залуу агрономч Зелик, механикч Саха, тракторчин Михайлов, Алексеев нар, тракторчин Найдан, Цэрэндорж, Сосорбурам нарын олон арван залуучуудыг дагалдуулан сургаж тэр жил энэ САА-д 15000 га атар газар хагалагдаж байсан бол энэ жил 9126 га газар хагалаж 29524 га газар үрлэх ажилд монгол, орос нөхөд мэр зэрэгцэн ажиллаж байна.

Яргуй цэнхэртсэн Ятуу-тын хөндийгөөр ороход Л.Магсаржамал даргатай 9 дүгээр бригадын орос, монгол техникчид хоёр салаа болж хоорондоо уралдан ажиллаж байгаа аж. Хөрсний эвдрэлтэй

тэмцэх арга технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн хөрнийг хавж хагалах, боловсруулах, үрлэх, булдах техник дээр ажиллаж байгаа ЗХУ-ын мэргэжилтэн, механикч В.И.Квартальны, тракторчин Н.К.Малейченко, Н.С.Рамонов нартай уулзахад: —Бид ЗХУ-ын Чуваский АССР Ростов, Ставрополь хязгаараас ирж атрын САА-н анд нөхөдөө туслан хөрнийг эвдрэлээс хамгаалах шинэ техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлж эхлэв.

Биднийг дагалдан ажиллаж байгаа Ш.Паламдорж, Ч.Болд, Д.Хишигхүү, Д.Доржсүрэн, Ж.Мягмар, Д.Алтангэрэл нарын олон сайчууд амжилттай сурч байна гэлээ.

Манайд хүний сор болсон тэргүүний хүмүүс олширч аймгийн хөдөлмөрийн аварга сайчууд, одон медаль, шагналтан олон арав боллоо.

Энэ бол Зөвлөлтийн мэргэжилтэн нөхдийн өглөг юм гэж өвгөн Д.Бэгз, Гүррагчаа нар ярьж байна. Тус САА-н хамт олон ургац хураалтын таван жилийн хөдөлсгүй төлөвлөгөөг нэг жилийн өмнө биелүүлэх зорилт бүхий уралдаан өрнүүлжээ.

Тус аж ахуйн 13 бригадын 6 нь ургац хураалтын таван жилийн төлөвлөгөөг 2 жилийн өмнө биелүүлсэн нь нийт тариаланчдын идэвхийг оргилууллаа.

1974 оныг газар тариалангийн үйлдвэрлэлд чанарын өөрчлөлт гаргахон болгон атрынхны 15 жилийн ойг хөдөлмөрийн өрнүүлэн амжилтаар угтаж өдөрт 640 га хагалаж, 3670 шахам га газар үрлэж аймгийн намын бага хурлыг ажлын амжилтаар угтаж байна.

Ш. ЦЭРЭНДОО

КУРГАН НУТГИЙН СОНИНООС

Бид Куртмашин районны Шмаковын ТМС, Лениний нэрэмжит хамтралд очиж ажил байдалтай нь танилцан, тус хамтрал ба манай аймгийн Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн хооронд байнгын харилцаа тогтоохоор тохиролцов.

Куртмашин районны СССР-ийн 50 жилийн ойн нэрэмжит Камканы САА-гаар очив. Энэ аж ахуйн үр тариа, нарийн ноост хонины аж ахуй эрхэлдэг юм.

Эртний хөгжилтэй, үлэмж үйлдвэрсэн Шадринский район, Шадринский хотын намын хорсо болон Притоболь районы намын хорооны ажилтай танилцлаа. Шадринский хотод авто машины эд ангийг үйлдвэрлэх завод, хэвлэлийн машины үйлдвэр, төмөрлөгийн болон телефоны орчин үеийн томоохон заводууд ажиллаж байна.

Мөн энэ районы Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт «Улаан-од» САА-н ажилтай танилцав. Энэ аж ахуй гахай үржүүлэх ба сүү, үр тарианы ажлыг дагнан явуулдаг ажээ.

Тус аж ахуй 12 жил дараалан ашигтай ажиллаж жилд 14 сая рублийн борлуулалт хийж 5 сая рублийн ашигтай ажиллаж байна. Ийм өндөр ашигтай ажиллаж байгаагийн үрээр өөрийн хөрөнгөөр районы төв хүртэл 18 км засмал зам тавьсан ба бригад фермүүд болон үйлдвэрлэлийн цэг хүртэл засмал зам тавихаар төлөвлөн өнөө жил 13 км-т тавьж 1,7 сая рублий зарцуулах юм байна.

САА-н дарга Г.М.Ефимов тус аж ахуйд 15 жил ажилласан, социалист хөдөлмөрийн баатар хүн юм. Энэ аж ахуйн тавьж байгаа нэг гол зорилт бол харьяандаа ажиллаж байгаа сургууль, эмнэлэг, ясли, цэцэрлэг зэрэг улсын төсвөөр ажилладаг байгууллагуудыг САА-н зардлаар санхүүжүүлэх арга хэмжээ авч байна.

Тус САА-гаас эх орны дайнд амь үрэгдсэн 40 гаруй дайчдад зориулж дургалын хөшөө босгожээ.

Энэ хөшөөний дэргэд сурагчид, залуучууд, САА-н нийт үйлдвэрлэлчид жил бүр хүндэтгэлийн тангараг өргөдөг журамтай юм.

Мөн В.И.Лениний хөшөөг босгожээ.

Төв аймаг, Курган мужийн хооронд 1974 онд хамтран ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зурах ажиллагаа мужийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргын өрөөнд болов.

Зөвлөлт-Монголын найрамдлын цуглааныг Курган хотын хүнд машин барилгын үйлдвэрийн ажилчдын соёлын ордонд 4 дүгээр сарын 12-нд хийв.

Цуглаанд 1200 гаруй хүн оролцсоны дотор Шмаковын ТМС-д суралцаж байгаа монгол сурагчдаас цөөн хүмүүсийг багш нарын нь хамт оролцууллаа.

Цуглааны ажиллагааг радио, телевизээр Курган муж даяар шууд дамжуулж байв.

Үргэлжлэл бий

НАМЫН МАЛЧИН ГИШҮҮДИЙН МАНАЙЛАЛ

Намын удирдах роль өсч байгаа одоогийн нөхцөлд олон түмний гүнд өдөр тутам ажилладаг коммунистуудын үүрэг асар их юм.

Аймгийн намын анхан шатны ихэнх байгууллагууд гишүүдийн манлайллыг хагас бүтэн жилээр дүгнэх, намын хурлаар манлайлалыг нь сонгож үнэлэлт өгөх, социалист уралдаанд үүрэг ажилт асаагуулах зэргээр тэдний манлайлах ролийг дээшлүүлэх ажил зохиож байна.

Энэ жил төлөвлөх зохио малын 10 гаруй хувь буюу 44,5 мянган малыг намын 200 шахам гишүүд хариуцан төлүүлнэ.

Одоо намын малчин гишүүд 32,7 мянган эхээс 32,9 мянган төл хүлээн авч 103 хувь бойжуулж байгаагийн дотор Эрдэнэсант сумын хоньчин, улсын аварга малчин Базаррагчаа, Алтанбулагийн Пү-

рэвдорж, Жаргалантын Жав, Банзрагч, хөдөлмөрийн баатар Б.Ажваа, Борнуурын Чимэдсүрэн, Эрдэнийн Найдан, Баянцогтын Юндэн, Эрдэнэсантын Хөндөр, Бадагч, Дэлгэрхааны Осорхүү, Лүнгийн Рэнцэндорж нарын зэрэг намын 80 гаруй гишүүд 430—640 мал төлүүлж 18—51 ихэртэй гарсан төл бүрийг мал болгож зүй бусаар нэгч мал хороолгүй сум, аймагтаа «Энх төлчин», «Мэнд сүрэгтэн» болжээ.

Аймгийн хэмжээгээр мал төлүүлж байгаа нийт намын гишүүдийн 93,7 хувь нь МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрт 100 эхээс бойжуулах төлийн талаар тавьсан зорилтыг биелүүлж хоёр мянган шахам төл илүү бойжуулах бололцоотой болсон байна. Өнгөрсөн онд аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа намын

гишүүдийн 59,1 хувь нь 100 эхээс бойжуулах төлийг МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрт хүргэж бойжууллаа. Аймгийн хэмжээгээр бүгд хурлын шийдвэрт хүргэж төлөх бойжуулсан суурийн хэмжээтэй харьцуулахад 37 гаруй хувиар дээгүүр байгаа бөгөөд малчин гишүүдийн 52,9 хувь нь малла зүй бусаар хорогдуулаагүй, 71,2—89,1 хувь нь сүү, ноос ноолуур, хөөвөр, хялгас зэрэг малаас ашиглах ашигшмын төлөвлөгөөг давуулж биелүүлжээ.

Гэвч намын анхан шатны зарим байгууллагаас гишүүдийнхээ манлайлыг жигд дээшлүүлэх талаар дутагдалтай ажиллаж бай-

түүнчилэн намын малчин гишүүдийн 61,4 хувь нь СХ-ийн хөдөлгөөнд хамрагдаагүй, мал өвөл-

жилт, төл хүлээн авах, отор нүүдэл хийх бэлтгэлийг намын малчин гишүүдээр үлгэр жишээчээр хангуулах зорилт жигд хэрэгжихгүй, уг ажил удааширч байгаагаас төл, том мал зүй бусаар хорогдох, хээл хаях, сувайрах явдал гарсаар байна.

Малын ашиг шинэ ашиглах хуулийн хугацааг орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоож, намын гишүүн нэг бүрт ойлгуулах, тэдний идэвхийг өрнүүлэх талаар ХАА-н нэгдэл, САА-н бригад, фермийн дэргэдэх намын үүр, хэсэг анхаарлаа төвлөрүүлэн хүн бүрийн ажлыг тодорхой дүгнэх явдал ч бас чамалттай байна.

Эдгээрээс дүгнэлт хийж намын малчин гишүүдийн манлайлыг дээшлүүлэхийн тулд намын анхан шатны байгууллагуудын товчооны гишүүд малчин гишүүдтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг нь сонсон, ажил төрлийн зөв-

дэлгөө, даалгавар өгөхөөс гадна тэдний төл бойжуулж байгаа байдал, малын зүй бус хорогдлын явцыг ойр ойрхон нэгтгэн судалж цуваагаар байр эзлүүлэн дүгнэж байх нь чухал.

Намын анхан шатны байгууллагууд намын малчин гишүүдийн төл бойжуултын одоогийн явц, МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрийг биелүүлэх боломж зэрэгт судалгаа дүгнэлт хийж малчдад социалист уралдаанд нэмэлт үүрэг асаагуулах ажлыг сайн зохион байгуулах хэрэгтэй.

Аймгийн намын XVI бага хурал угтаж ХАА-н үйлдвэрлэлийн болон бэлтгэлийн төлөвлөгөөт ажлыг ханган биелүүлэхэд намын байгууллагууд үзэл суртал зохион байгуулалтын ажлыг чиглүүлэн энэ ажилд коммунистуудыг үлгэр жишээчээр ажиллуулбал зохино.

Г. ЖАЛБАА

ТӨЛ БҮРИЙН ТӨЛӨӨ

Манай аймагт 1974 онд 634,3 мянган мал төлдөөс одоогийн байдлаар 474,8 мянга буюу төлөх малын 75 хувь нь төлөж 473,4 мянган төл бойжиж, төл бойжилт 98,8 хувьтай байна.

Төл бойжуулах бэлтгэлийг чанартай ханган, аж ахуй, зохион байгуулалтын арга хэмжээг бүх талаар жигд авч явуулан, малчид, төлчдийн улс төр, хөдөлмөрийн идэвхийг өрнүүд чадсан Баянцагаан, Баян, Өндөрширээт Эрдэнэсэнт сумдын төл 99,8-100 хувь бойжиж байна.

Мөн аймгийн хэмжээгээр хөрвийн аргыг зааврын дагуу чанартай хэрэглэж, төлийн арчидгаа маллагаанд нягт нямбай хандан ажиллаж байгаа 200 гаруй суурь 100 хээлгэгчээс бойжуулах төлийн талаар МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас дэвшүүлсэн зорилгыг биелүүлээд байна.

Гэтэл Бүрэн, Заамар, Эрдэнэ сумд төл бойжилтын ажилд тавих хяналт шалгалт, мэргэжлийн удирдлагыг сулруулснаас гарсан төлийнхөө 2,7—4,5 хувийг хорогдуулаад байна. Мөн төл бүрийг арчилж бойжуулах, төлийн хорогдол гарч байгаа суурьт яаралтай арга хэмжээ авах, өвчилсөн төлийг цаг алдалгүй, тогтмол эмчилж эдгэрүүлэх явдал хангалтгүй байснаас Борнуур сумын 5—6 суурьт 80 гаруй тугал, Батсүмбэр сумын нэг суурьт 50 гаруй хурга хорогдож байхад, хорогдлыг зогсоох байтугай хэ-

дэн төл хорогдоод байгааг мэдээгүй байлаа.

Энэ байдалд дүгнэлт хийж, төл бойжуулах ажлыг улам эрчимжүүлэн, гарсан төл бүрийг мал болгоход нам, улс, олон нийт, хөдөө аж ахуйн байгууллагууд ажлаа чиглүүлэх явдал шаардагдаж байна.

Одоо бог мал төлөж дуусах дөхөж байгаа ба зарим сумдад бог малын

цох явдал чухал. Одоо өвөлжөө, хаваржааны шар бууцнаас гарч, саравчтай хашааныхаа хажууд хөнгөн маягийн хашаа, нөмөр бэлтгэн төлөө оруулж тэнгэр муудаж шаардлага гарсан үед саравч мүнз рүүгээ төл малаа оруулж байх нь зүйтэй байна.

Нийт төл хөрвөжин өвсөн тэжээлд орж элдэв хог ноос идэж бөөнтөж үхэх явдал гардгийг анхаарч, төлд өгөх өвс тэжээлийг онгоц тавиурт тавих, хөдлөж уях зэргээр өгч байвал зохино.

Хотын ариун цэврийг эрс сайжруулж эргүү болон бусад өвчин үүсгэгчийг төл, том мал идэж

байвч суурь бүрт татаж нөөцлөхгүй, малаа тэжээхгүй байгаа, зарим сумд өвс тэжээлгүй атлаа ногоо гарах дөхөж байна гэж тайвшран, аймгийн фонд, тэжээлийн үйлдвэрүүдээс хуваарьтай тэжээлээ татаж авахгүй байгаа явдлыг анхаарч, хуваарьтай тэжээлийг нэн даруй татан авч ашиглах явдал чухал байна.

Одоо гарцхүү төл малыг анхаараад зогсохгүй нийт малын хариулга маллагааг улам сайжруулж хужир усаар тогтмол ханган шавар усанд унахаас хамгаалж, ногоо цухуйн, яргуй цэцэглэж малын гүйдэл ихдэн, бэлчээр нь



Бүрэн сум-нэгдлийнхоньч Ц. Мандалсүрэн 125 хонь, 117 ямаа төлүүлээд гарсан төлөө 10 хэртэйгээр бүрэн мөнд бойжуулж байна.

ТӨЛ БОЙЖУУЛАХ АЖЛЫГ УЛАМ ЭРЧИМЖҮҮЛЬЕ

төлд голлон анхаарч, бусад төрлийн малын төлд тавих анхаарал хяналтыг сулруулснаас ялангуяа тугалын уураг бөөгнөрөх, хатгалга тусах, чацага алдах зэрэг халдваргүй өвчнөөр үхэх явдал нилээд гарч байна.

Иймд малын төл нэг бүрт тавих анхаарлыг жигд сайжруулж, тэжээлийн горим алдаж гэдэс нь өвчилсөн төлийг тараг, ходоодны шүүсээр эмчлэх, чацага алдан шингэнээ их хэмжээгээр алдсан тугал бусад төлд физиологийн уусмалыг арьсан доогуур нь тарьж эмчлэх нь үрдүн сайтай байгааг анхаарч ажиллавал зохино. Төлийг нэгбүрчлэн тоолж, сэнсрэх төлөв орсон төлийг ялгаж нэмэгдэл тэжээлд оруулах энэ жил төлөвөл зохих эх малд хээлийн шалгалт дахин хийж, хээл хаясан төлдөсөн, одоо төлөх, сувайрыг нягтлан тогтоож, тоо-

өвчилөх явдлаас сэрэмжлэл зохино.

Бог малын төлийг сэнсрэхээс хамгаалахын тулд эхтэй нь бэлчээрт явуулдгийг зогсоож нөмөр дулаан, гуу жалга, яргуй ногоотой газраар идээшлүүлэх, нэг лааз өтгөрүүлсэн сүүг 2 л усанд найруулан хөөрүүлээд өгөх, 1 кг хуурай сүүг 10 литр усанд найруулж хөөрүүлээд бүлээнээр нь төлд өдөрт 2—3 удаа 200—500 граммаар өгөх, овьёосны зутан, сүүнд агшасан будаа, гурилын зутан (5—6 литр ус ба шөлөнд 300—500 грамм гурил хийж буцалган хөргөөд) зэргээр тэжээх нь зүйтэй.

Ийм журмаар арчилж тэжээсэн төл турж сэнсрдэггүй байна.

Ер нь хаарын хавсрага, ногоон зудны үе эхлэж байна.

Ийм үед зарим сум—нэгдлүүд өвс, тэжээл

холдож байгааг эрс анхаарч, харгана, сөөг, хачиг, хувалз багатай, яргуй, ногоотой бэлчээрт тогтуун хариулж маллавал зохино.

Эрлийз цэвэр үүлдрийн үхэртэй сүүний чиглэлийн аж ахуйнууд тугалыг эхээс гарсны дараа 7—14 хоног эхтэй нь хамт байлган уурганд нь бүрэн цагтаж, түүнээс хойш эхээс нь салгаж тусгай малчинд 25—30-аар нь хариуцуулж тугалыг нь тэжээж, үнээг саалинд гаргаж, тугал тэжээх жорыг нарийн мөрдөж ажиллах нь чухал байна.

Унагыг хүлээн авч бойжуулахдаа унагалах гүүг азрагатай нь ялган, хоньчлон хариулах, ботгыг завал гардан хүлээн авч, шорвог цай, хярмаар амлуулж зулайг нөхөх, нэмнэх, уях шаардлагыг хангавал зохино.

ХААУ газрын орлогч дарга М. НЯМАА

Үзлэгийн өмнө

Баянзүрх сумын 8 жилийн дунд сургууль төрийн яамдын өмч хамгаалалт, хууль дүрмийн үзлэгт бэлтгэх төлөвлөгөө зохион, хуулийн булан байгуулан хууль дүрэм судлах ба сурталчлах 7 хоног явуулж сургууль, сурагчдын холбогдолтой хууль дүрэм, тогтоол заавруудаар цуврал яриа лекц хийж сурагчдаас хууль дүрмийн мэдлэгийн шалгалт авч, эцэг эх, хөдөлмөрдөд багш нараар яриа хийлгэв.

Мөн өмч хөрөнгийг засаж сэлбэн эд материалд тэмдэг ярилж хийв. Аймгийн прокурор БНМАУ-ын гавьяат хуульч О. Лхам сүрэнтэй багш, ажилчид сурагчдын уулзалт зохиож МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 24 дүгээр тогтоол, танихайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээгдэх хариуцлагыг чангатгах, согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай хууль дүрмүүдээр яриа хийлгэв.

Ц. БУДЖАВ

Өдөрлөг болов

Архустын ТАА-н бага сургууль 1973—1974 оны хичээлийн жилд явагдсан эх энгийн сурган хүмүүжүүлэх хичээлийн дүнг ярилцаж сургуулиа сурталчлан таниулах өдөрлөг зохиов.

Өдөрлөгт сургуулийн түүх, танилцуулга, сурагчдын хийсэн уран бүтээл, сурах бичиг хичээлийн хэрэгслийн үзэсгэлэн, багш нараас хичээлд хэрэглэсэн үзүүлэн болон «Манай сургууль», «Цэвэр бичигтэн» зэрэг самбар хийж хөдөлмөрчдөд үзүүлж сурагчдын концерт тоглөв.

Д. ШАРАВ

АДУУ ХӨӨВӨРЛӨВ

Борнуурын САА-н албан байгууллагын ажилтан, ажилчид 2 өдөр адуу хөөвөрлөж 132,8 кг хөөвөр авч тушаав.

Адуу хөөвөрлөлийн үеэр зарласан уралдаанд САА-н холбооны салбар, ясли, цэцэрлэгийн хамт олон хошуучлав.



Баянжаргалан сумын «Шинэ амьдрал» нэгдлийн «Балд-эрхтэй» бригадын хоньчин, ХЗЭ-ийн илгээлтийн эзэн Х. Ишжамц малын төл сайн бойжуулан авч байгаагийн зэрэгцээ эмнэг тэмээг уналга эдэлгээнд сургаж нөхдөө хошуучлаж байна.

Хоньчин Х. Ишжамц эмнэг тэмээг бага нлсанд нь унаж эдэлж сургах нь сайн гэж үздэг юм.

ЗУРАГ ДЭЭР: Ишжамц

П. ЖАНЧИВ-ийн авсан гэрэл зураг

ЗӨВЛӨЛТИЙН ХЭВЛЭЛИЙН ХӨГЖИЛТ

ЗХУ-ын Большевик намын хэвлэл, «Правда» сонины анхны дугаар 1912 оны 5 дугаар сарын 5-нд хэвлэгдэн гарчээ.

Одоо ЗХУ-д 15,0 мянга орчим сонин сэтгүүл 300 сая, «Правда», «Известия», «Комсомольская правда», «Сельская жизнь», «Труд», «Пионерская правда» зэрэг сонинууд 7—10 гаруй сая ширхэгээр хэвлэгдэж байна.

«Работница», «Здоровье» зэрэг сэтгүүлүүдийг жил тутам тус бүр 10 гаруй сая хүн захиалж байна.

Сүүлийн 8 жилд сонин 70 хувиар, сэтгүүл 2,0 гаруй дахинаар ихэсжээ.

ЗХУ-ын 2 мянга гаруй хэвлэлийн үйлдвэрт сонин хэвлэгдэж 236 хэвлэлийн газар, 4 мянга орчим хэвлэлийн үйлдвэрүүдэд ном товхимол хэвлэгдэн гарч байна.

ЗХУ-д «Правда» сониныг 42, «Известия» сониныг 40 хотод хэвлэдэг.

Одоо сонины барыг холбооны 20 салбараар дамжуулж байгаа бол ойрын 3—4 жилд шинээр 20 хотод дамжуулдаг болж олон арван хотын оршин суугчид төвийн сонинг хэвлэгдсэн өдөрт нь унших бололцоотой болох юм.

ТАСС бол дэлхий дээр тэмдэглэн агентлагуудийн нэг бөгөөд зөвлөлт орны болон хилийн чанадад орнуудад болж байгаа үйл явдлын талаар 4,0 мянга орчим мэдээллийг зөвлөлтийн сонин, гадаадын сурвалжлагаанд хүлээн авч ашигладаг.

ЗХУ-ын ном хэвлэлийн газруудад хагаа сая хүн ажилладаг ба зөвхөн сэтгүүлчдийн холбоо 50 мянган гишүүнтэй юм. Социалист орнуудын хэвлэлийн газруудтай хамтран ажиллах явдал өргөжиж тулгамдсан чухал асуудлаар 1973 онд 70 гаруй номыг хамтран бүтээжээ.

Н. ХАНДСҮРЭН

Банкны байгууллагын 50 жилд

Тусгай нэрийн хадгаламж

Хөдөлмөрдийн гар дээр байгаа сул чөлөөтэй мөнгийг банканд өргөн хадгалуулах зорилгоор сүүлийн үед хадгаламжийн хэлбэрүүд олширч байгаагийн дотор тусгай нэрийн хадгаламж гэдэг шинэ хэлбэр бий болж байна. Үүнтэй холбогдуулж тусгай нэрийн хадгаламж гэж юуг хэлэх, түүний ач холбогдлын талаар дор нийтлэв.

«Тусгай нэрийн хадгаламж» нь хувийн хадгаламжийн өсөлтөнд нөлөөлж байгаа ба хөдөлмөрдийн сонирхолд ч нийцжэ байна.

Тусгай нэрийн хадгаламж гэдэг нь төрсөн өдрийн ой хийх, гэр бүл болох, хурим хийх, шинэ гэр барих, өндөр насны тэтгэвэрт орох, үнэт эдлэл худалдан авах зэрэгт зориулан уг арга хэмжээнийхээ нэрээр мөнгө хуримтлуулан хадгалуулахыг хэлдэг.

Сүүлийн үед тухайлбал хүүхдийг төрсний өдрөөс нь эхлэн 18 нас хүртэл өцгө эх нь өөрсдийн цалингаас тус бүр 25 төгрөг бүгд 50 төгрөг хуримтлуулан хадгаламж и н д хийгээд байвал жилд 600 төгрөг хуримтлагдаж 18 жилийн дараа банкинд хийсэн мөнгө нь 10800 төгрөг болж хадгаламжийн хүүд 13910 төгрөг нэмэгдэн бүгд 24710 төгрөг болж өснө.

Анд найз нарынхаа хурим хийх, төрсөн өдрийн ой, сургууль төгссөний байр зэрэгт уригдан очигд тус бүрдээ бэлэг авч өгөхийн оронд зөвхөн мөнгө нийлүүлж уг ёслолд холбогдох нэрийн хадгаламж нээлгээд, хадгаламжийн дэвтрийг нь багтаа цэцэгтэй бэлэглэх нь тун таашаалтай зүйл юм.

Ийм хадгаламжийг на-

сан туршдаа эзэмшин дуртай зүйлдээ зарцуулж, урт удаан хугацаагаар баяжуулан хэрэглэдэгээс анд найз нараа дурсан санаж явах болно.

Тусгай нэрийн хадгаламж нь хүмүүсийн амьдралд соёлч боловсон заншил нэвтрүүлэн, хөдөлмөрдийн мөнгөн орлогоо зөв зохистой зарцуулахад нь туслах ач холбогдолтой юм.

МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурлын шийдвэрийг биелүүлэх, хөдөлмөрийн цагийг хэмнэж, банкны үйлчилгээг хөдөлмөрдөд ойртуулан хөнгөн шуурхай болгох зорилгоор банкны тооцооны кассыг олноор байгуулахын зэрэгцээгээр бэлэн бусаар хадгаламж нээх журмыг нэвтрүүлж байна. Бэлэн бус хадгаламжийг явуулахдаа байгууллагын захиргаа, банкны байгууллагын хооронд тохиролцсоны үндсэн дээр томилогдсон идэвхтнээр дамжуулан ажилчин, албан хаагчдын сайн дурын үндсэн дээр, тэдний хүсэлт зөвшөөрлөөр сар бүр ийн цалингаас 1-2 удаа суутгал хийж хувийн хадгаламжинд бэлэн бусаар оруулах явдал юм. Энэ хэлбэр манай аймгийн зарим байгууллагууд дээр амжилттай хийгдэж байна.

Я. ДОЛЖИНЖАВ

Чөлөөлөгдсөний нь 29 жилийн ойд

БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ЧЕХОСЛОВАК УЛС

БНСЧСУ нь газрын бөмбөргийн хүн амын 0,4 орчим хувь, нутаг дэвсгэрийн 0,08 хувийг эзэлдэг ба ХАА-н нэг га газарт ноогдох ХАА-н бүтээгдэхүүний талаар дэлхийд дээгүүр ордог 10 орны тоонд багтдаг билээ.

БНСЧСУ нь төв европт оршдог бөгөөд 127,9 мянган квадрат км нутаг, 14,5 сая хүн амтай, 25 жилд тус орны аж үйлдвэрийн үйлдвэрлэл нь 7,6 дахин, үүний дотор машины үйлдвэрийнх 16 гаруй дахин, химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн бараг 19 дахин, барилгын ажлын хэмжээ 8,6 дахин өсчээ. 1968—1972 о н д 36,0—48,0 миллиард киловат цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэжээ.

Чехословак, хоёр ул-

(Хөгжлийн тоо баримт) сн хөгжлийн эдийн засгийн түвшинг жигдрүүлэх зорилгоор таван жилд нийгмийн бүтээгдэхүүнийг Чех улсад 15 хувь, Словак улсад барагцаалвал 40 хувиар өсгөхөөр төлөвлөжээ.

Мөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ Чех улсад 27—29 хувь, Словак улсад 55—57 хувиар өсөх юм.

Сүүлийн 25 жилд Чехословакад 1,7 сая сууцны шинээр барьж засварлан ашиглалтанд өгсний гадна барилгын ажлын хэмжээ 8 дахин өсчээ.

Сүүлийн 20 жилд хүн амын бодит орлого 2 гаруй дахин ихэссэн байна. БНСЧСУ-д зуун айл тутамд 154 радио хүлээн авагч, угаалгын 96 ма-

шин, 66 хөргөгч, 83 телевизор, 22 автомашин ноогдож байна.

Жилд нэг хүн 45 метр бөс бараа, 5 хос гутал, 341 киловат цаг цахилгаан эрчим хүч, 83,7 куб метр түлшний хий хэрэглэж байна.

ЭЗХТ Зөвлөлийн цогцолбор программын дагуу БНСЧСУ нь 1971-1975 онд социалист ах дүү орнуудад (валютаар тооцоход) 6,0 миллиард коронын үнэ бүхий машины төрөлжсөн бүтээгдэхүүн нийлүүлэх юм.

1990 он хүртлэх хугацаанд экспортод гаргах машин тоног төхөөрөмж нь дөрөвний нэгээр ихсэж, гадаадаас авах машины үйлдвэрийн бүтээгдэхүүн барагцаалвал 21 хувьд хүрнэ.

Н. ХАНДСҮРЭН



Сайхан явагдсан «Анхдугаар таван жил» сонин нэрэмжит волейболчин аварга шалгаруулах тэмцээнд тэргүүн байр эзэлсэн НААУГ-ын эрэгтэй, эмэгтэйчүүдийн багийн талархид.

Л. ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг

ТОВЧХОН

Аймгийн Соёлын ордны урлаг ухуулгын бригадынхан бүх сум-нэгдэл, САА, ТАА зарим бригад тасгаар орж урлагаар үйлчлэв. Тус бригадынхан малын-зүй бусын хорогдлыг багасгаж арга зам, төлийг хөрвөжилтийн үе шатаар бойжуулж буй арга зэрэг 10 гаруй сэдвээр лекц яриа хийсний гадна МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн тухай самбар үзүүлэн гаргаж сурталчлав.

Тэд түүвэр болон ардын дууны цоморлиг концертыг «Амьдралын алхам» жүжгээр 80 гаруй удаа тоглолт хийжээ.

Мөн тус бригадынхан очсон газрынхаа клубуудан-булангуудын ажилд биеллэн туслаж сайн дурын уран сайханчдын үзлэрт бэлтгэж байгаа уран сайхандаа дуу, хөгжим, бүжгийн талаар зөвлөгөө өглөө.

Ш. ЦЭРЭНДОО

Асуулт хариултын уралдааны болзол

Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгийн аймгийн салбар, аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны Ардын боловсролын хэлтсээс МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны түүхэн замналыг пионер сурагчдад танилцуулах зорилгоор асуулт хариултын уралдааныг тус аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 4—10 дугаар ангийн пионер сурагчдын дунд 1974 оны 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1 хүртэл хугацаатай зарлаж байна.

1 дүгээр асуулт. МАХН-ын III их хурал хэдийд хаана хуралдаж ямар түү-

хэн чухал шийдвэр гаргасан бэ?

2 дугаар асуулт. Монгол улсыг Бүгд Найрамдах Бүрэн Эрхтэй ард улс гэж тунхагласны ач холбогдол.

3 дугаар асуулт. Дахрээний тухай юу мэдэх вэ?

4 дүгээр асуулт. Улсын нийслэлийг «Улаанбаатар» хот гэж хэдийд нэрлэсэн бэ?

Эдгээр дөрвөн асуултыг хариулахдаа холбогдох зураг, баримал, сийлбэр, наамал, хатгамал, цоолбор зураг, урлалын зүйлийн хамт ирүүлж болно. Уралдаанд тэргүүн байр эзэлсэн 10 пионер

сурагчдыг тусгай шагналаар шагнаж уралдаанд идэвхтэй оролцсон сурагчдад түүхт ойн нэрэмжит талархалын хуудас дурсгана.

Хариултыг «Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны Ардын боловсролын хэлтэст» гэсэн хаягаар хүлээн авна.

Пионер сурагчид аа! МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтан зарлаж байгаа асуулт хариултын уралдаанд пионер сурагч бүр идэвхтэй оролцохыг уриалж байна.

ЭРДЭМ ДЭЛГЭРҮҮЛЭХ НИЙГЭМЛЭГИЙН АЙМГИЙН САЛБАР АЙМГИЙН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ АРДЫН БОЛОВСРОЛЫН ХЭЛТЭС

лөгөөг 100—106,2 хувиар биелүүлэн бүх ноолуураа 1 дүгээр зэрэгт тусшааж социалист уралдаанд хошуучилж явна.

Л.ДОЛГОР

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЦӨӨН МӨРӨӨР

Алтанбулаг сумын «Жаргалант» бригадын хоньчин Намжим, Ц. Донгормаа, С. Цэвэгмид, Д. Догсом нар ноолуурын төлө-

СУББОТНИКООР

Эрдэнэ сумын төвийн 15 байгууллагын 600 гаруй хүн, ямаа самнах, мал бэлтгэлийн хашаа сэлбэх, нэгдсэн бойны газрыг тохижуулах авто болон ХАА-н машины гараашийн хашаа барих, Архустын ТАА-нхан үтрэм, агуулахаа засч, тохижуулах, үр хордуулах, наркуулах зэрэг ажлыг «Жанчивлин»-гийн рашаан сувилалынхан талхны газрыг өргөтгөх зэргээр сумын хэмжээгээр 400 гаруй төгрөгийн ажил хийлээ.

Бүх нийтийн суббоотникт сургууль комбинат, ТАА, дунд сургууль, ХБ-ийн анги, хүн эмнэлэг зэрэг байгууллага бусдаасаа давуу бүтээлтэй ажиллав.

Д.ОТГОН